



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 13

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө худалдах, үндсэн хөрөнгө акталж,
сэлбэг хэрэгслээр ашиглах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 37-36 ДУА улсын дугаартай KIA BONGO маркийн автомашиныг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, сэлбэг хэрэгслээр ашиглах, нийт 2,245,467,42 (хоёр сая хоёр зуун дөчин таван мянга дөрвөн зуун жаран долоон төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 534,635,40 (таван зуун гучин дөрвөн мянга зургаан зуун гучин таван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй “Ус цэнгэгийн барилга”-ыг хоёрдугаар хавсралтын дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (О.Бархүү)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, данс бүртгэлээс хасах, хөрөнгө худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцан харуул хамгаалалттай байлгах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;


2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 77 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
тогтоолын хавсралт

Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
сэлбэг хэрэгслээр ашиглах хөрөнгийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэл		Үйлдвэрлэ сэн он	Ашиглалтан д орсон он	Балансын үнэ	Хурумтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			сери	дугаар					
1	Дундговь-Ус ОНӨААТҮГ	KIA BONGO	ДУА	37-36	2006	2006	1,500,000	1,500,000	-
Нийт дүн							1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг	1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг	-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
23 тогтоолын хавсралт

Дундговь-Ус" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
нээлттэй дуудлагын худалдаагаар оруулах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгуула мжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглал танд орсон огноо	Ашиглал тын нийт хугацаа / жилээр /	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			ХЭМ ЖИХ НЭГЖ	БИЕТ ХЭМЖЭ Э							
1	Ус цэнгэгийн барилга (доорх газаргүй)	Бохир соруулах	м2	6	1998	7	1	2,101,207,77	1,710,832,02	534,635,40	1,500,000
Нийт дүн								2,101,207,77 хоёр сая нэг зуун нэг мянга хоёр зуун долоон төгрөг далан долоон мөнгө) төгрөг	1,710,832,02 (нэг сая долоон зуун арван мянга найман зуун гучин хоёр) төгрөг	534,635,40 (таван зуун гучин дөрвөн мянга зургаан зуун гучин таван төгрөг дөчин мөнгө) төгрөг	1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг